ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 25 өдөр Дугаар А/02 Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн тогтоох тухай" 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад компьютер, техник хэрэгсэл худалдан авах ажлыг "Саммит компьютер технологи" хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Некст электроникс" хязгаарлагдмал хариуцлагатай компанитай тус тус шууд худалдан авах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.

3. Санхүүжилтээ авахад шаардлагатай материал бүрдүүлэн авч "Саммит комьютер технологи" хязгаарлагдмал хариуцлагатай компанид 7,999,300 (долоон сая есөн зуун ерэн есөн мянга гурван зуу) төгрөг, "Некст электроникс" хязгаарлагдмал хариуцлагатай компанид 2,499,900 (хоёр сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуу) төгрөг нийт 10,499,200 (арван сая дөрвөн зуун ерэн есөн мянга хоёр зуу) төгрөгийг гэрээний дагуу Засаг даргын Тамгын газрын багаж техник хэрэгслийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ

C:My Doc A-4 tushaal /ZDTG/